



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.09.25 № А-12/744
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Таны ирүүлсэн хүсэлтийн дагуу тэтгэврийн зээлийн 2020 оноос 2025 оны 08 дугаар сар хүртэлх мэдээллийг доорх хүснэгтээр хүргүүлж байна. Мөн бусад улс орны тэтгэврийн зээлийн туршлага холбоотой танилцуулгыг хавсаргасан болно.

Хүснэгт 1. Тэтгэврийн зээлийн мэдээ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025.08
Тэтгэврийн зээлийн үлдэгдэл	48.6	221.3	517.4	1,183.8	1,629.3	2,289.7
Үүнээс:						
Анхаарал хандуулах зээл	0.1	0.1	1.7	7.1	14.4	28.3
Зээлд эзлэх жин	0.1%	0.0%	0.3%	0.6%	0.9%	1.2%
Чанаргүй зээл	0.9	0.8	2.1	5.0	9.7	17.4
Зээлд эзлэх жин	1.8%	0.4%	0.4%	0.4%	0.6%	0.8%
Зээлийн дансны тоо	51,097	105,316	187,345	254,414	271,287	289,812
Тайлант хугацаанд олгосон зээл	308.2	543.9	1,286.1	2,257.5	2,895.0	2,519.9
Тайлант хугацаанд төлөгдсөн зээл	1,021.2	373.6	989.9	1,592.0	2,447.9	1,859.0
ЖДХүү	16.6%	15.1%	14.7%	15.9%	15.9%	17.3%
ЖДХугацаа, сараар	5.4	6.6	8.9	11.9	13.2	15.5

Эх сурвалж: Монголбанк

Дээрх мэдээлэл нь Монголбанкны цахим хуудсанд сар бүр зарлагддаг тул тус холбоосоор <https://stat.mongolbank.mn/finance> хандан мэдээллийг харах боломжтой.

Хавсралт 1 хуудастай.

СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ



Д.ДАВААСҮХ

1525022949

ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮ, ХУГАЦААНЫ БУСАД УЛС ОРНЫ ТУРШЛАГА

Ихэнх улс орнуудад тэтгэврийн орлогыг хэрэглээний зээлийн барьцаа болгон ашиглаж, орлогоос нь суутган зээл олгох зохицуулалт төдийлөн түгээмэл бус байна. Харин иргэдийн хуримтлуулсан тэтгэврийн сангаас зээл авах боломж олон улсад харьцангуй өргөн хүрээнд нэвтэрчээ. Тухайлбал, АНУ-д иргэд өөрсдийн тэтгэврийн хуримтлалын данс болох 401(k)-аа барьцаалан зээл авах боломжтой байдаг бол Австрали, Шинэ Зеланд, БНСУ, Япон зэрэг улс орнуудад орон сууцны үнэлгээнд тулгуурласан, ахмад настнуудад чиглэсэн буцаан төлөгдөх зээлийн (*reverse mortgage*) тогтолцоо өргөнөөр ашиглагддаг. Эдгээр тохиолдолд зээлийн барьцаа нь иргэний тэтгэврийн орлого бус, хуримтлал эсвэл үл хөдлөх хөрөнгө байдаг тул зах зээлийн дундажтай харьцуулахад харьцангуй таатай нөхцөлөөр, хүү багатай зээл олгох боломж бүрддэг онцлогтой байна. Харин тэтгэврийн сангаас иргэдэд олгож буй тогтмол орлогыг барьцаалан зээл авах хэлбэрийн зохицуулалт нь олон улсад харьцангуй хязгаарлагдмал, цөөн хэдэн улс оронд хэрэгждэг. Энэ төрлийн зээлийн бүтээгдэхүүн нь тухайн улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, болон санхүүгийн дэд бүтцээс хамаарч өөр өөр нөхцөл, хязгаарлалттайгаар хэрэгждэг. Жишээлбэл: Филиппин, Энэтхэг, Монгол зэрэг улс орнууд тэтгэврийн орлогод суурилсан зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Гэсэн хэдий ч эдгээр зээлийн хүүний түвшин, эргэн төлөх хугацаа, мөн зээлдэгчийн нас болон зээлийн дээд хэмжээ зэрэгт тодорхой хязгаарлалтуудтай байдаг.

Үзүүлэлт	Филиппин	Энэтхэг	Монгол
Банкны нэр	GSIS Financial Center	State Bank of India	Голомт банк
Хүү	10.0% + premium rate (наснаас хамаарч нэмэгдэнэ)	10.85%-11.90%	16.8-18.0%
Хугацаа	78-с доош настай байх 24 сар хүртэл	76-с доош настай байх 72 сар хүртэл, 78 насанд төлөгдсөн байх	Насны хязгаарлалтгүй 18 сар хүртэл
Олгож буй тэтгэвэр зээлийн хэмжээ	2 сарын тэтгэвэр хүртэл (70-78 нас), 4 сарын тэтгэвэр хүртэл (65-69 нас) 6 сарын тэтгэвэр хүртэл (65 доош нас)	15 сарын тэтгэвэр хүртэл	18 сарын тэтгэврийн 70%- иас нийт хүүгийн зардлыг хассан дүн хүртэл
Зориулалтын хязгаарлалт	Зээлийн хэмжээ P500,000~USD\$8,800 хэтрэхгүй	Байхгүй	Байхгүй
Зээл олголт, судалсны шимтгэл	2.0%	0.5%	Байхгүй
Батлан даалт шаардах эсэх	Заавал биш	Заавал	Заавал биш
Сарын зээлийн төлбөр тэтгэврийн харьцаа	25%-иас хэтрэхгүй	50%-иас хэтрэхгүй	70%-иас хэтрэхгүй



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Энхтайваны өргөн чөлөө 19, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14210, Монгол Улс
Утас: (976-11) 312 362, 331 133, Факс: (976-11) 325 449
Э-шуудан: info@tdbm.mn, Вэб хуудас: www.tdbm.mn

2025. 10. 09 № 5/15028
танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Ахмад настнуудад олгогддог тэтгэврийн зээлийн бүтээгдэхүүнийг ХХБ-ны зүгээс ашиг олох бус нийгмийн хариуцлагын хүрээнд олгож буй зээл гэж авч үздэг. Үүний хүрээнд бид тухайн зээлийг шимтгэлгүй аль болох харилцагчид уян хатан нөхцөлөөр, бага хүүтэй олгохыг зорин ажилладаг.

Одоогийн тэтгэврийн зээлийн хүү нь зах зээл дээр банкны өөрийн эх үүсвэрээр олгогдож буй зээлүүдээс хамгийн бага хүүтэй (сарын 1.4%) байгаа. Өмнөх хэлэлцүүлэгт дурдсанаар зээлийн хүү нь эх үүсвэрийн өртөг, эрсдэл болон ашиг гэсэн ерөнхий хэд хэдэн үзүүлэлтээс бүрдэж байгаа ба одоогийн нөхцөлд зээлийн хүүг үүнээс илүү бууруулах боломжгүй байна.

Гэхдээ засгийн газрын зүгээс банкуудад хөнгөлөлттэй эх үүсвэр, эсвэл хүүгийн татаас олгох зэрэг арга замаар тухайн зээлийн хүүг бууруулах боломжтой харагдаж байна.

Иймд, тухайн зээлийн хүүг бууруулах хуулийн төсөл хэлэлцэх, иргэдийн амьжиргаанд тулгуурлан зээлийн нөхцөлийг сайжруулахаар зорин ажиллаж байгаа бол дээрх саналыг авч хэрэгжүүлэх нь илүү бодитой үр дүн гаргах боломжтой гэдгийг уламжилж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ОРЛОГЧ



П.МӨНХНАСТ

2577457



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Бага тойруу 7/1,
Утас: 310103, Факс: (976-11)-319044
www.statebank.mn, Лавлах төв: 1800-1881

2025.10.01 № 018/5261

танай _____ -ны № _____ -т


**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.МӨНХТУЛГА ТАНАА**

Хариу хүргүүлэх тухай


Тэтгэврийн зээлийн хүүгийн талаарх 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцон, манай банкны зүгээс бодит нөхцөл байдал болон байр сууриа илэрхийлсэн билээ.

Төрийн банкны хувьд тэтгэврийн зээлийн хүүгийн талаарх хуулийн төслийн санаачилгыг дэмжиж байгаа бөгөөд арилжааны банкууд нь ахмадын тэтгэврийн зээлийн хүүг бууруулах асуудалд нэгдсэн санал, тооцоо судалгааг бэлтгэн Монголын банкны холбоонд хүргүүлж, тус холбоогоор дамжуулан албан ёсны саналыг хүргүүлэх болно.

БИЗНЕС ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТЭРГҮҮН ОРЛОГ



15170064596



ХААН БАНК

ХХД-9007001013
ХААН БАНК ЦАМХАГ
Чингисийн өргөн чөлөө-6,
Стадион Оргил-1, Хан-Уул
дүүрэг, Улаанбаатар 17010,
Монгол Улс
Утас: (976)-75153333
Факс: (976)-70117023
www.khanbank.com

2025 оны 10 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 01 / 6059

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.МӨНХТУЛГА ТАНАА

УИХ -03/11221 албан бичигт
хариу хүргүүлэх тухай

Танд энэ өдрийн мэндийг хүргэе.

ХААН Банкны хувьд тэтгэврийн орлого барьцаалсан зээлийг олгохдоо зохицуулагч байгууллагуудын тушаал шийдвэр, журмыг ханган ажиллахын зэрэгцээ компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд тэтгэвэр авагч иргэддээ тэдний санхүүгийн хэрэгцээг хангах хамгийн боломжтой нөхцөлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгохыг зорьж ажилладаг.

Тэтгэврийн зээлийн хувьд 2024-2025 онд зохицуулалттай холбоотой хэд хэдэн томоохон өөрчлөлтүүд орсон. Тодруулбал, 2025 онд гарсан Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А-57 дугаар шийдвэрээр “Тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд зээлийн сарын төлбөрөө төлсний дараах зээлдэгчийн үлдэх орлого нь хүн амын амьжиргааны доод түвшнээс доошгүй байх”, 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А-143 дугаар шийдвэрийн дагуу “Тэтгэвэр тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр орлогын харьцааны дээд хязгаарыг 50%-иар тогтоох”, 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар “Тэтгэвэр тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр орлогын харьцаанд хязгаар тавихгүй байх” гэх мэт шийдвэрүүдийг ХААН Банк тухай бүр хэрэгжүүлэн ажилласаар ирсэн.

2025 оны 10 дугаар сарын байдлаар ХААН Банкаар дамжуулан нийт 330 мянга орчим харилцагчдад төрөөс олгож буй тэтгэвэр, тэтгэмжээ авч байгаагаас 180 мянган харилцагч нь тэтгэврийн орлогоо барьцаалан зээл авсан байгаа ба банкны тэтгэврийн зээлийн багц 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Эдийн засгийн идэвхжил, баяр ёслолын үеэс хамааран сардаа 150-250 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийг банк олгодог.

ХААН Банкны тэтгэврийн орлого барьцаалсан зээлийн хүү 2022 онд мөнгөний бодлогын хүү 6 хувь байхад жилийн 14.4% -15.6% байсан бол 2025 оны 10 сарын байдлаар бодлогын хүү 12% байхад жилийн 16.8%-18.0% хувийн хүүтэйгээр санал болгож байна. Энэхүү хүүний өөрчлөлт нь бодлогын хүүний өсөлт болон банкны эх үүсвэрийн зардалтай шууд холбоотой байна.

Иймд төр засгийн зүгээс дараах арга хэмжээг авбал тэтгэврийн зээл хүү буурах боломжтой гэж харж байна.

- Тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэсэн активын хувь хэмжээг ердийн зээлтэй адилтган тооцох (Тэтгэврийн зээл 150%, ердийн зээл 100% байдаг)
- Засгийн газраас тэтгэврийн зээлийн багцын түвшинд эрсдэлийн баталгаа гаргах тохиолдолд банкууд зээлийн эрсдэлийн сан байгуулахгүй байх
- Тэтгэврийн зээл олгоход шаардагдах эх үүсвэрийг хүүгүй эсвэл бага хүүтэй олгох
- Тэтгэврийн зээлд шаардагдах эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн тооцооллоос хасах

ХААН Банкны зүгээс компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгын дэмжсэн, тэтгэвэр авагч харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг гаргахад цаашдаа хамтран ажиллахад нээлттэй байгаагаа үүгээр илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.МӨНХТУЯА